



Монголын Социал Демократ Намын
Улс Төрийн Зөвлөлийн 2012 оны 5-р
сарын 1-ний хурлаар батлав.

X32822

Монголын Социал Демократ Намын Улсын Их Хурлын 2012 оны сонгуулийн мөрийн хөтөлбөр

Энэ удаагийн УИХ-ын сонгууль нь Монгол улсын Үндсэн хуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх, төрийн тогтолцоог сонгодог ардчилсан зарчимд нийцүүлэх, үндэсний баялагаа зөв ашиглаж улс орноо хөгжүүлэн, ард иргэдээ эрх чөлөө амьдралын баталгаагаар найдвартай хангах түүхэн сонголтын цаг үе ирлээ хэмээн манай нам үзэж байна. Энэхүү түүхэн сорилт нь улс үндэстний эрх ашгийг дээдэлсэн, иргэний нийгмийг төлөвшүүлэх, бодит ардчиллыг тогтоох стратегийн зорилгоор тодорхойлогдоно. Үүний тулд:

- ✓ Улс төрийн тогтолцооны өнөөгийн гаж бүтэц, үйл ажиллагаа, арга барил зэрэг нь бүхэлдээ шинэ Үндсэн хууль нэгэнт амьдрал, практикт нийцэхгүй болсны баталгаа хэмээн үзэж Үндсэн хуулийг бүхэлд нь өөрчлөх шаардлагатай гэж үзнэ.
- ✓ Шилжилтийн үед эрх мэдлийг авилга, хээл хахуулийн аргаар авсан улс төрийн тодорхой бүлэглэл, бие хүмүүсийн хуйвалдааныг таслан зогсоож, тэдэнтэй хуулийн дагуу хариуцлага тооцох, тэднийг улс төрийн талбараас шударгаар зайлуулах хос зорилтыг хэрэгжүүлэх түүхэн шаардлага, зайлшгүй зорилт Монголын улс төрд тулгараад байна.

Харьцангуй асар их нөөц баялаг, том газар нутаг, цөөн хүн ам бүхий урагш хөгжин дэвжих боломжтой манай оронд нүүрлэсэн өнөөгийн хямралыг өдөөгч гол хүчин зүйл нь төрд шургалж, ард түмнийг бэлэн мөнгөний амлалтаар хууран мэхэлж, луйвардаж ирсэн, үндэсний ашиг сонирхолд ноцтой хохирол учруулагч цөөн тооны олигархи явцуу бүлэглэлүүд мөн.

Энэ бүлэглэлүүд хоорондын зөрчилдөө идэгдэж, эрх мэдлийн төлөөх бохир тэмцэлдээ улс орон ард иргэдийг хохироон самууруулж буйг ард түмэн нийтээрээ нэгэнт мэдэж, жигшин зэвүүцэх боллоо. Тэд урьдын адил сонгогчдын саналыг худалдан авах, үл биелэгдэх хуурамч хөтөлбөр дэвшүүлж олон түмнийг төөрөгдүүлэх зэрэг хуучин бохир аргаа дахин хэрэглэхээр зэхэж байна. Монголчууд бид улс төр бизнесийн эдгээр бүлэглэлүүдэд дахин хууртвал үндэсний сүйрэлд хүрэх аюултай тулгарна гэдгийг ард түмэндээ онцлон анхааруулж байна.

“МСДН” өнөөгийн Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаа Иргэний нийгмийн байгууллагууд, Олон нийтийн хөдөлгөөн, Улс төрийн намуудын үзэл санаа, тэмцлийн

туршлагыг судалж, Монголын нөхцөл байдалд шинжилгээ, дүгнэлт хийсэн олон улсын байгууллага, гадаад дотоодын эрдэмтдийн оюун сэтгэлгээний ололтод тулгуурлан төр, нийгмийн шинэчлэлийн хөтөлбөрөө боловсруулж ард иргэд, нийт сонгогчиддоо толилуулж байна.

Манай намын хөтөлбөр нь зөвхөн энэ удаагийн сонгуульд бус Монгол эх орноо одоогийн Улс төр, Эдийн засгийн хямралт байдлаас аврах, сэргээн хөгжүүлэх, хүчирхэгжүүлэх гэсэн шинжлэх ухааны үндэстэй урт хугацааны стратеги төлөвлөгөө болохыг нийт сонгогчиддоо толилуулж байна.

Бидний зорилго, баримтлах зарчим

Монголын нийгэм Улс төрийн гүнзгий хямрал, эдийн засгийн олигополист гажиг тогтолцооны улмаас гаж, замбараагүйтлийн төлөв байдалд орсон гэж манай “МСДИ” үзэж байна. Нийгмийн ийм төлөв байдлаас бид зөвхөн зоригтой, эрс шийдэмгий алхам хийж байж гарч чадна. Иймийн учир манай нам шүтэн барилдлага, уялдаа бүхий дараах тулгуур зарчмуудыг баримтлан ажиллана.

Монгол төрийн нэг гарт нь хуулийн ташуур, нөгөө гарт нь энэрэнгүйн таяг байх ёстой. Монгол бол ядарсан мэт боловч ядарсан биш, эв нэгдэлтэй мэт боловч задарсан нийгмээр замнах боллоо. Монгол бол харахад гэмгүй мэт боловч гэмт хэрэгжсэн нийгэм болж байна. Иймээс Монгол улсад эмх цэгц, дэг журмыг хатуу, туйлбартай аргаар тогтоох шаардлагатай боллоо. Монголд шударга ёс, иргэнлэг хууль, тэгш эрхийн зарчмыг хэрэгжүүлэх ёстой гэж манай нам үзэж байна.

Нөгөө талаас Монголын төр нь өндөр настан, олон хүүхэдтэй эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу зүдүү нийгмийн эмзэг бүлгүүдээ хайрлаи хамгаалж, энэрэнгүйн гараа харамгүй сунгах ёстой хэмээн манай нам үзэж байна. Төр нь насанд хүрсэн, боловсрол эзэмшсэн, бие эрүүл, хөдөлмөрийн чадвартай хүмүүсийг зүгээр тэжээн, хөдөлмөрлөх эрхийг нь хааж боох бус тэдэнд шударга тэнцүү гарааны нөхцлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

Төрийн хатуу, зөөлөн хоёр талыг зөв зохистой хослуулах нь Монгол улсын төрийн бодлогын эрхэм чухал, хэлбэрэлтгүй чиг шугам, тулгуур зарчим байх ёстой.

Нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд зөвхөн эдийн засаг, улс төр төдийгүй үзэл санаа, ёс суртахуун, соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, спорт, эрүүл мэнд, гэр бүл, аюулгүй байдал, экологи зэрэг нийгэм бүрдүүлэгч үндэсн хүчин зүйлүүдийг цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ гэмт хэргээс хамгаалж, амьдралын эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх нь Монгол төрийн эн тэргүүний зорилт мөн.

Бидний уриа

“МСДН”, Улсын Их Хурлын 2012 оны сонгуульд Хяналттай төр, Тэгш бололцоо уриатайгаар орж байна. Эрүүл төр, эрүүл нийгэм, эрүүл байгаль, тэйцвэртэй эрхийн төлөө тэмцэлд иргэн таны оролцоо хамгаас чухал хэрэгтэй. Төрийн бохирдол, нийгмийн бохирдол, байгалийн бохирдлыг бид хамтын хүчээр зогсоох цаг боллоо. Үүнийг зөвхөн хяналттай төр, тэнцвэртэй эрхийн зарчмаар л хэрэгжүүлнэ. Энэ бол 22 жилийн өмнө Монголд эхэлсэн улс төрийн ардчиллыг улам гүнзгийрүүлж, өнөөгийн нийгмийн хямралыг гэтлэн давж, улс орондоо эрх зүйт ардчилсан, шударга төрийг цэгцлэн байгуулах, иргэний бодит ардчиллыг тогтоох нийгмийн хөгжлийн дараагийн үе шат юм.

Төрөө иргэний хяналттай, иргэд нь тэнцвэртэй эрхтэй, өрх гэр бүлийн амьжиргаатай, иргэдээ нутаг орных нь эзэн болгох “МСДН”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр хэрэгжсэнээр Монголын төр эрүүлжиж, ард иргэдийн амьдрал сайжирч, байгаль дэлхий экологийн сүйрлийн аюулаас холдох болно гэдэгт бид гүнээ итгэж байна.

1. Хяналттай төр

Иргэний хяналттай төрийн тогтолцоо

- ✓ Төрийн үйл ажиллагаанд хяналт тавих Иргэний танхимийг малчид, бизнес эрхлэгчид, багш, эмч, эрдэмтэд зэрэг Монголын нийгмийн гол давхаргын төлөөлөлтэйгээр УИХ-ын дэргэд байгуулна.
- ✓ УИХ-ын гишүүн, бүх шатны Иргэдийн хурлын төлөөлөгч зэрэг сонгуульд албан тушаалтныг эргүүлэн татах тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Төрийн өндөр албан тушаалтнуудын авилга, луйврын хэргийг шүүхэд шилжүүлж, тэдний эд хөрөнгө, газрын лицензийг хянан шалгуулна.

Иргэндээ үйлчилдэг төрийн байгууллага

- ✓ Хүнд суртлыг багасгаж иргэнийг төрийн аль шатны байгууллага, албан тушаалтан 20 минутаас илүү хүлээлгэхгүй, хоёроос дээш удаа явуулахгүй байх зэрэг төрийн үйлчилгээний хатуу журам, стандарт тогтоож мөрдүүлнэ.
- ✓ Төрийн үйлчилгээг аажмаар иргэний нийгмийн байгууллагуудад гэрээлэн шилжүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, хөнгөн шуурхай болгох зорилгоор төрийн үйлчилгээг Интернетээр авах, мэдээлэл авах нөхцөлийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлнэ.

Иргэний мэдээллийн эрх

- ✓ Төрийн нууцаас бусад төрийн аль ч мэдээллийг иргэдэд ил тод болгоно. Гэмт үйлдлийн шинжтэй мэдээллийг төрийн нууцад хамааруулах явдлыг таслан зогсоож,

олон нийтэд худал болон зөрчилтэй мэдээлэл өгсөн, мэдээллийг нуун дарагдуулсан, хоцроосон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.

- ✓ Интернетээр дамжуулан олон нийтэд зориулан 60 хоногийн өмнө нийтэлж, нээлттэй хэлэлцүүлэг хийгээгүй хуулийн төслийг УИХ-д хэлэлцэхийг хязгаарлан, иргэдийн санал хуульд тусгах нөхцлийг бүрдүүлнэ.
- ✓ Олон нийтийн радио, телевизийг улс төрчдийн хяналтаас бүрэн гаргаж, хүчирхийлэл, садар самуун, гаж үйлдэл зэргийг өдөөгч мэдээллийн терроризмыг таслан зогсооно.

Төр, намын ажлын зааг ялгаа

- ✓ Улс төрийн намуудыг хатуу гишүүнчлэлгүй болгон, төрийн албан хаагчдыг намын үзэл суртлаас бүрэн чөлөөлнө.
- ✓ Улс төрийн намуудыг хатуу гишүүнчлэлгүй болгосноор, иргэдийн үзэл бодлоороо сонголтоо хийх боломжийг чөлөөтэй болгон, намуудын санхүүжилтийг ил тод болгон, тогтмол нийтэд зарлаж байна.
- ✓ Төрийн захиргааны болон намуудын аппаратын ажилтнуудын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдохыг хориглож, улс төрийн ба төрийн албан хаагчдын зааг ялгааг хуулийн хүрээнд хангаж өгнө.

Сонгууль, санал асуулга

- ✓ Сонгуулийн хувь тэнцүүлсэн / пропорциональ / тогтолцоог 50:50-ийн харьцаатай нэр дэвшүүлдэг системд шилжүүлж, намаас сонгогдох төлөөллүүдийг Үндсэн хуулийн заалтад нийцүүлэн хүнийг сонгодог зарчмыг хуульчилж, бүх шатны сонгуулийн байгууллагыг улс төрийн намуудын нөлөөллөөс ангижруулна.
- ✓ Сум хороодын түвшинд улс төрийн намуудын оролцоог халж, хурлын төлөөллийг иргэдээс сонгодог болгоно. Бүх шатны засаг дарга нарыг иргэд шууд сонгодог болгоно.
- ✓ Ард нийтийн санал асуулгын тогтолцоог боловсронгуй болгож нийгмийн бүлгүүдийн санал асуулгын сүлжээг төгөлдөржүүлэн хөгжүүлнэ.

2. Амьжиргаатай өрх, алдагдалгүй төсөв

Монголын өрх бүрийг хөгжлийн босгоор алхуулж, залуучууд идэр насныханд боломж олгож, ахмадууд хүүхдүүдэд халамж хүргэсэн иргэн төвтэй эдийн засгийн бодлого хэрэгжүүлнэ. Манай нам “Хөгжлийн босго” буюу монгол өрх, улс орны амьжиргааны доод үзүүлэлтийг :

Иргэн бүрт эрүүл мэнд, боловсрол, цэвэр хүнс гэсэн 3 үндсэн зарчмийг тодорхойлж байна. Энэхүү “Хөгжлийн босго”-ыг нийгмийн болон байгалийн баялгийг шударгаар хуваарилах, авилгалын сүлжээг задлах, далд эдийн засгийг ил

болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр хангах бүрэн боломжтой.”Хөгжлийн босго” зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл:

Хүний хөгжил

- ✓ Өрх гэр бүлийг дэмжих бодлогыг хатуу баримталж хүүхэд бүрт нийгмийн хараа хяналтыг хүргэж, хөгшдөд нийгмийн халамж хүртээнэ.
- ✓ Боловсролын салбарт эрс шинэчлэл хийж, хүн бүрийг мэргэжилтэй, өрсөлдөн амьдрах чадвартай болгох төрийн бодлого хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагуудын сургалтын агуулга тогтолцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Бизнес, аж ахуй

- ✓ Үндэсний үйлдвэр, хөдөө аж ахуйг шинэчлэн сэргээн байгуулж, өрсөлдөх чадвартай, экологийн цэвэр бүтээгдхүүний үйлдвэрлэлийг тэргүүлэн хөгжүүлнэ. Үндэсний үйлдвэр, хөдөө аж ахуйг хамгаалах, урамшуулах тууштай, хатуу бодлого баримтлана.
- ✓ Аж ахуй дах төрийн оролцоог хязгаарлаж, бизнест дарамт учруулж буй хууль тогтоомж, журмыг өөрчлөн шинэчлэх шийдвэртэй арга хэмжээ авна. Бизнесийн лиценз олголт, мэргэжлийн хяналтын үүргийг биенесийн өөрөө удирдах зарчмаар ажиллах салбарын хороодод шилжүүлнэ.
- ✓ Хөдөлмөрийн хөлсийг цагаар тооцдог тогтолцоонд шилжинэ. Залуу, дунд насны иргэдийг мэргэшүүлэх, давтан сургах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Ядуурлын эсрэг

- ✓ Стратегийн ордуудаас олох орлогыг шударга бус хувварилж буй явдлыг таслан зогсоож ядуурлын хувийг бууруулах чиглэлд зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ.

3.Эзэнтэй нутаг

Нутгийн өөрөө удирдах зарчим

- ✓ ИТХ-ын эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлж, орон нутгийн татварын бие даасан тогтолцоог бий болгоно.
- ✓ Хөдөө орон нутагт жижиг бизнес, хувиараа аж ахуй эрхлэгчдийг улсаас татварын уян хатан бодлогоор дэмжинэ.
- ✓ Байгалын баялаг олборлох, ашиглах тогтолцоог бүхэлд нь орон нутагт шилжүүлэх эрх зүйн тогтолцоог бий болгоно.

Байгаль орчин, экологи

- ✓ Экологийн глобаль өөрчлөлтүүдийг тооцон, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, өнөөгийн экологийн сүйрлийг таслан зогсооно. Нутаг усыг сүйтгэсэн, хордуулсан хохирлын цар хэмжээг тогтоож, улмаар нөхөн сэргээлгэх, хор уршгийг арилгуулах эрс шийдэмгий арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- ✓ Байгалийн баялагийн үнэлгээ, ашиглалтын өнөөгийн тогтолцоог бүрэн өөрчилж, экологийн урамшуулал, татвар, торгууль, стандартын шинэ тогтолцоог бий болгоно.
- ✓ Гол усны эх, ай сав газарт алтны болон бусад баялагын олборлолтыг бүрэн хориглоно.


Уул уурхай, ашигт малтмал

- ✓ Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ. Эцсийн бүтээгдэхүүний болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж бүс нутаг дахь эдийн засгийн оролцоог нэмэгдүүлнэ.
- ✓ Стратегийн орд газруудыг түшиглэн Уул уурхайн хөрөнгө оруулалтын дэлхийн түвшний үндэсний корпораци байгуулж ажиллуулна. Иргэн бүрт Стратегийн орд газруудын хувьцааг олгох ажлыг тасралтгүй хэрэгжүүлэн, орд газруудын “IPO”-г олон улсын хөрөнгийн зах зээлд гарган хөрөнгө босгох замаар Монголчууд өөрсдөө ашиглан, баялгийн хуваарилалтыг ард түмэнд хүргэх ажлыг тууштай хэрэгжүүлнэ.
- ✓ Хууль бусаар олгогдсон лицензүүдийг хурааж, гадаадын байгууллагууд Монголын газар нутаг дах лицензүүдийг өөр хоорондоо наймаалцдаг асуудлыг бүрмөсөн зогсооно.

Төр нийгэм, байгаль дэлхийгээ эрүүл, цэвэр байлгаж, төр засаг, нутаг орон, өрх гэрийнхээ жинхэнэ эзэд болж явах нь монголчууд бидний Монголдоо сайхан амьдрах гол зарчим билээ. Эрүүл төр, эрүүл амьдрал, эрүүл нутгийнхаа төлөө хамтдаа зүтгэе. Эх орондоо тэнцвэртэй эрх, тэгш бололцоо, шударга ёсыг хэрэгжүүлбэ.

Монголын Социал Демократ Нам





Монголын Социал Демократ Намын
Улс Төрийн Зөвлөлийн 2012 оны 5-р
сарын 1-ний хурлаар батлав.

Монголын Социал Демократ Намын Улсын Их Хурлын 2012 оны сонгууллийн мөрийн хөтөлбөр

Энэ удаагийн УИХ-ын сонгууль нь Монгол улсын Үндсэн хуулийн тогтолцоог төгөлдөржүүлэх, төрийн тогтолцоог сонгодог ардчилсан зарчимд нийцүүлэх, үндэсний баялагаа зөв ашиглан улс орноо хөгжүүлэн, ард иргэдээ эрх чөлөө амьдралын баталгаагаар найдвартай хангах түүхэн сонголтын цаг үе ирлээ хэмээн манай нам үзэж байна. Энэхүү түүхэн сорилт нь улс үндэстний эрх ашгийг дээдэлсэн, иргэний нийгмийг төлөвшүүлэх, бодит ардчиллыг тогтоох стратегийн зорилгоор тодорхойлогдоно. Үүний тулд:

- ✓ Улс төрийн тогтолцооны өнөөгийн гаж бүтэц, үйл ажиллагаа, арга барил зэрэг нь бүхэлдээ шинэ Үндсэн хууль нэгэнт амьдрал, практикт нийцэхгүй болсны баталгаа хэмээн үзэж Үндсэн хуулийг бүхэлд нь өөрчлөх шаардлагатай гэж үзнэ.
- ✓ Шилжилтийн үед эрх мэдлийг авилга, хээл хахуулийн аргаар авсан улс төрийн тодорхой бүлэглэл, бие хүмүүсийн хуйвалдааныг таслан зогсоож, тэдэнтэй хуулийн дагуу хариуцлага тооцох, тэднийг улс төрийн талбараас шударгаар зайлуулах хос зорилтыг хэрэгжүүлэх түүхэн шаардлага, зайлшгүй зорилт Монголын улс төрд тулгараад байна.

Харьцангуй асар их нөөц баялаг, том газар нутаг, цөөн хүн ам бүхий урагш хөгжин дэвжих боломжтой манай оронд нүүрлэсэн өнөөгийн хямралыг өдөөгч гол хүчин зүйл нь төрд шургалж, ард түмнийг бэлэн мөнгөний амлалтаар хууран мэхэлж, луйвардаж ирсэн, үндэсний ашиг сонирхолд ноцтой хохирол учруулагч цөөн тооны олигархи явцуу бүлэглэлүүд мөн.

Энэ бүлэглэлүүд хоорондын зөрчилдөө идэгдэж, эрх мэдлийн төлөөх бохир тэмцэлдээ улс орон ард иргэдийг хохироон самууруулж буйг ард түмэн нийтээрээ нэгэнт мэдэж, жигшин зэвүүцэх боллоо. Тэд урьдын адил сонгогчдын саналыг худалдан авах, үл биелэгдэх хуурамч хөтөлбөр дэвшүүлж олон түмнийг төөрөгдүүлэх зэрэг хуучин бохир аргаа дахин хэрэглэхээр зэхэж байна. Монголчууд бид улс төр бизнесийн эдгээр бүлэглэлүүдэд дахин хууртвал үндэсний сүйрэлд хүрэх аюултай тулгарна гэдгийг ард түмэндээ онцлон анхааруулж байна.

“МСДН” өнөөгийн Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаа Иргэний нийгмийн байгууллагууд, Олон нийтийн хөдөлгөөн, Улс төрийн намуудын үзэл санаа, тэмцлийн

туршлагыг судалж, Монголын нөхцөл байдалд шинжилгээ, дүгнэлт хийсэи олон улсын байгууллага, гадаад дотоодын эрдэмтдийн оюун сэтгэлгээний ололтод тулгуурлан төр, нийгмийн шинэчлэлийн хөтөлбөрөө боловсруулж ард иргэд, нийт сонгогчиддоо толилуулж байна.

Манай намын хөтөлбөр нь зөвхөн энэ удаагийн сонгуульд бус Монгол эх орноо одоогийн Улс төр, Эдийн засгийн хямралт байдлаас аврах, сэргээн хөгжүүлэх, хүчирхэгжүүлэх гэсэн шинжлэх ухааны үндэстэй урт хугацааны стратеги төлөвлөгөө болохыг нийт сонгогчиддоо толилуулж байна.

Бидний зорилго, баримтлах зарчим

Монголын нийгэм Улс төрийн гүнзгий хямрал, эдийн засгийн олигополист гажиг тогтолцооны улмаас гаж, замбараагүйтлийн төлөв байдалд орсон гэж манай “МСДН” үзэж байна. Нийгмийн ийм төлөв байдлаас бид зөвхөн зоригтой, эрс шийдэмгий алхам хийж байж гарч чадна. Иймний учир манай нам шүтэн барилдлага, уялдаа бүхий дараах тулгуур зарчмуудыг баримтлан ажиллана.

Монгол төрийн нэг гарт нь хуулийн ташуур, нөгөө гарт нь энэрэнгүйн таяг байх ёстой. Монгол бол ядарсан мэт боловч ядарсан биш, эв нэгдэлтэй мэт боловч задарсан нийгмээр замнах боллоо. Монгол бол харахад гэмгүй мэт боловч гэмт хэрэгжсэн нийгэм болж байна. Иймээс Монгол улсад эмх цэгц, дэг журмыг хатуу, туйлбартай аргаар тогтоох шаардлагатай боллоо. Монголд шударга ёс, иргэнлэг хууль, тэгш эрхийн зарчмыг хэрэгжүүлэх ёстой гэж манай нам үзэж байна.

Нөгөө талаас Монголын төр нь өндөр настан, олон хүүхэдтэй эхчүүд, хөгжлийн бэрхшээлтэй болон ядуу зүдүү нийгмийн эмзэг бүлгүүдээ хайрлан хамгаалж, энэрэнгүйн гараа харамгүй сунгах ёстой хэмээн манай нам үзэж байна. Төр нь насанд хүрсэн, боловсрол эзэмшсэн, бие эрүүл, хөдөлмөрийн чадвартай хүмүүсийг зүгээр тэжээн, хөдөлмөрлөх эрхийг нь хааж боох бус тэдэнд шударга тэнцүү гарааны нөхцлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

Төрийн хатуу, зөөлөн хоёр талыг зөв зохистой хослуулах нь Монгол улсын төрийн бодлогын эрхэм чухал, хэлбэрэлтгүй чиг шугам, тулгуур зарчим байх ёстой.

Нийгмийн тогтвортой байдлыг хангахын тулд зөвхөн эдийн засаг, улс төр төдийгүй үзэл санаа, ёс суртахуун, соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, спорт, эрүүл мэнд, гэр бүл, аюулгүй байдал, экологи зэрэг нийгэм бүрдүүлэгч үндсэн хүчин зүйлүүдийг цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ гэмт хэргээс хамгаалж, амьдралын эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх нь Монгол төрийн эн тэргүүний зорилт мөн.

Бидний уриа

“МСДН”, Улсын Их Хурлын 2012 оны сонгуульд Хяналттай төр, Тэгш боллоцоо уриатайгаар орж байна. Эрүүл төр, эрүүл нийгэм, эрүүл байгаль, тэнцвэртэй эрхийн төлөө тэмцэлд иргэн таны оролцоо хамгаас чухал хэрэгтэй. Төрийн бохирдол, нийгмийн бохирдол, байгалийн бохирдлыг бид хамтын хүчээр зогсоох цаг боллоо. Үүнийг зөвхөн хяналттай төр, тэнцвэртэй эрхийн зарчмаар л хэрэгжүүлнэ. Энэ бол 22 жилийн өмнө Монголд эхэлсэн улс төрийн ардчиллыг улам гүнзгийрүүлж, өнөөгийн нийгмийн хямралыг гэтлэн давж, улс орондоо эрх зүйт ардчилсан, шударга төрийг цэгцлэн байгуулах, иргэний бодит ардчиллыг тогтоох нийгмийн хөгжлийн дараагийн үе шат юм.

Төрөө иргэний хяналттай, иргэд нь тэнцвэртэй эрхтэй, өрх гэр бүлийн амьжиргаатай, иргэдээ нутаг орных нь эзэн болгох “МСДН”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр хэрэгжсэнээр Монголын төр эрүүлжиж, ард иргэдийн амьдрал сайжирч, байгаль дэлхий экологийн сүйрлийн аюулаас холдох болно гэдэгт бид гүнээ итгэж байна.

1. Хяналттай төр

Иргэний хяналттай төрийн тогтолцоо

- ✓ Төрийн үйл ажиллагаанд хяналт тавих Иргэний танхимийг малчид, бизнес эрхлэгчид, багш, эмч, эрдэмтэд зэрэг Монголын нийгмийн гол давхаргын төлөөлөлтэйгээр УИХ-ын дэргэд байгуулна.
- ✓ УИХ-ын гишүүн, бүх шатны Иргэдийн хурлын төлөөлөгч зэрэг сонгуульд албан тушаалтныг эргүүлэн татах тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Төрийн өндөр албан тушаалтнуудын авилга, луйврын хэргийг шүүхэд шилжүүлж, тэдний эд хөрөнгө, газрын лицензийг хянан шалгуулна.

Иргэндээ үйлчилдэг төрийн байгууллага

- ✓ Хүнд суртлыг багасгаж иргэнийг төрийн аль шатны байгууллага, албан тушаалтан 20 минутаас илүү хүлээлгэхгүй, хоёроос дээш удаа явуулахгүй байх зэрэг төрийн үйлчилгээний хатуу журам, стандарт тогтоож мөрдүүлнэ.
- ✓ Төрийн үйлчилгээг аажмаар иргэний нийгмийн байгууллагуудад гэрээлэн шилжүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, хөнгөн шуурхай болгох зорилгоор төрийн үйлчилгээг Интернетээр авах, мэдээлэл авах нөхцөлийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлнэ.

Иргэний мэдээллийн эрх

- ✓ Төрийн нууцаас бусад төрийн аль ч мэдээллийг иргэдэд ил тод болгоно. Гэмт үйлдлийн шинжтэй мэдээллийг төрийн нууцад хамааруулах явдлыг таслан зогсоож,

олон нийтэд худал болон зөрчилтэй мэдээлэл өгсөн, мэдээллийг нуун дарагдуулсан, хоцроосон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.

- ✓ Интернетээр дамжуулан олон нийтэд зориулан 60 хоногийн өмнө нийтэлж, нээлттэй хэлэлцүүлэг хийгээгүй хуулийн төслийг УИХ-д хэлэлцэхийг хязгаарлан, иргэдийн санал хуульд тусгах нөхцлийг бүрдүүлнэ.
- ✓ Олон нийтийн радио, телевизийг улс төрчдийн хяналтаас бүрэн гаргаж, хүчирхийлэл, садар самуун, гаж үйлдэл зэргийг өдөөгч мэдээллийн терроризмыг таслан зогсооно.

Төр, намын ажлын зааг ялгаа

- ✓ Улс төрийн намуудыг хатуу гишүүнчлэлгүй болгон, төрийн албан хаагчдыг намын үзэл суртлаас бүрэн чөлөөлнө.
- ✓ Улс төрийн намуудыг хатуу гишүүнчлэлгүй болгосноор, иргэдийн үзэл бодлоороо сонголтоо хийх боломжийг чөлөөтэй болгон, намуудын санхүүжилтийг ил тод болгон, тогтмол нийтэд зарлаж байна.
- ✓ Төрийн захиргааны болон намуудын аппаратын ажилтнуудын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд сонгогдохыг хориглож, улс төрийн ба төрийн албан хаагчдын зааг ялгааг хуулийн хүрээнд хангаж өгнө.

Сонгууль, санал асуулга

- ✓ Сонгуулийн хувь тэнцүүлсэн / пропорциональ / тогтолцоог 50:50-ийн харьцаатай нэр дэвшүүлдэг системд шилжүүлж, намаас сонгогдох төлөөллүүдийг Үндсэн хуулийн заалтад нийцүүлэн хүнийг сонгодог зарчмыг хуульчилж, бүх шатны сонгуулийн байгууллагыг улс төрийн намуудын иелөөллөөс ангижруулна.
- ✓ Сум хороодын түвшинд улс төрийн намуудын оролцоог халж, хурлын төлөөллийг иргэдээс сонгодог болгоно. Бүх шатны засаг дарга нарыг иргэд шууд сонгодог болгоно.
- ✓ Ард нийтийн санал асуулгын тогтолцоог боловсронгуй болгож нийгмийн бүлгүүдийн санал асуулгын сүлжээг төгөлдөржүүлэн хөгжүүлнэ.

2. Амьжиргаатай өрх, алдагдалгүй төсөв

Монголын өрх бүрийг хөгжлийн босгоор алхуулж, залуучууд идэр насныханд боломж олгож, ахмадууд хүүхдүүдэд халамж хүргэсэн иргэн төвтэй эдийн засгийн бодлого хэрэгжүүлнэ. Манай иам “Хөгжлийн босго” буюу монгол өрх, улс орны амьжиргааны доод үзүүлэлтийг :

Иргэн бүрт эрүүл мэнд, боловсрол, цэвэр хүнс гэсэн 3 үндсэн зарчимийг тодорхойлж байна. Энэхүү “Хөгжлийн босго”-ыг нийгмийн болон байгалийн баялгийг шударгаар хуваарилах, авилгалын сүлжээг задлах, далд эдийн засгийг ил

болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр хангах бүрэн боломжтой.”Хөгжлийн босго” зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл:

Хүний хөгжил

- ✓ Өрх гэр бүлийг дэмжих бодлогыг хатуу баримталж хүүхэд бүрт нийгмийн хараа хяналтыг хүргэж, хөгшдөд нийгмийн халамж хүртээнэ.
- ✓ Боловсролын салбарт эрс шинэчлэл хийж, хүн бүрийг мэргэжилтэй, өрсөлдөн амьдрах чадвартай болгох төрийн бодлого хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагуудын сургалтын агуулга тогтолцоог орчин үеийн шаардлагад нийцүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Бизнес, аж ахуй

- ✓ Үндэсний үйлдвэр, хөдөө аж ахуйг шинэчлэн сэргээн байгуулж, өрсөлдөх чадвартай, экологийн цэвэр бүтээгдхүүний үйлдвэрлэлийг тэргүүлэн хөгжүүлнэ. Үндэсний үйлдвэр, хөдөө аж ахуйг хамгаалах, урамшуулах тууштай, хатуу бодлого баримтлана.
- ✓ Аж ахуй дах төрийн оролцоог хязгаарлаж, бизнест дарамт учруулж буй хууль тогтоомж, журмыг өөрчлөн шинэчлэх шийдвэртэй арга хэмжээ авна. Бизнесийн лиценз олголт, мэргэжлийн хяналтын үүргийг биенесийн өөрөө удирдах зарчмаар ажиллах салбарын хороодод шилжүүлнэ.
- ✓ Хөдөлмөрийн хөлсийг цагаар тооцдог тогтолцоонд шилжинэ. Залуу, дунд насны иргэдийг мэргэшүүлэх, давтан сургах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Ядуурлын эсрэг

- ✓ Стратегийн ордуудаас олох орлогыг шударга бус хувварилж буй явдлыг таслан зогсоож ядуурлын хувийг бууруулах чиглэлд зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ.

3.Эзэнтэй нутаг

Нутгийн өөрөө удирдах зарчим

- ✓ ИТХ-ын эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлж, орон нутгийн татварын бие даасан тогтолцоог бий болгоно.
- ✓ Хөдөө орон нутагт жижиг бизнес, хувиараа аж ахуй эрхлэгчдийг улсаас татварын уян хатан бодлогоор дэмжинэ.
- ✓ Байгалын баялаг олборлох, ашиглах тогтолцоог бүхэлд нь орон нутагт шилжүүлэх эрх зүйн тогтолцоог бий болгоно.

Байгаль орчин, экологи


- ✓ Экологийн глобаль өөрчлөлтүүдийг тооцон, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, өнөөгийн экологийн сүйрлийг таслан зогсооно. Нутаг усыг сүйтгэсэн, хордуулсан хохирлын цар хэмжээг тогтоож, улмаар нөхөн сэргээлгэх, хор уршгийг арилгуулах эрс шийдэмгий арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- ✓ Байгалийн баялагийн үнэлгээ, ашиглалтын өнөөгийн тогтолцоог бүрэн өөрчилж, экологийн урамшуулал, татвар, торгууль, стандартын шинэ тогтолцоог бий болгоно.
- ✓ Гол усны эх, ай сав газарт алтны болон бусад баялагын олборлолтыг бүрэн хориглоно.

Уул уурхай, ашигт малтмал

- ✓ Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ. Эцсийн бүтээгдэхүүний болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж бүс нутаг дахь эдийн засгийн оролцоог нэмэгдүүлнэ.
- ✓ Хууль бусаар олгогдсон лицензүүдийг хурааж, гадаадын байгууллагууд Монголын газар нутаг дах лицензүүдийг өөр хоорондоо наймаалцдаг асуудлыг бүрмөсөн зогсооно.

Төр нийгэм, байгаль дэлхийгээ эрүүл, цэвэр байлгаж, төр засаг, нутаг орон, өрх гэрийнхээ жинхэнэ эзэд болж явах нь монголчууд бидний Монголдоо сайхан амьдрах гол зарчим билээ. Эрүүл төр, эрүүл амьдрал, эрүүл нутгийнхаа төлөө хамтдаа зүтгэе. Эх орондоо тэнцвэртэй эрх, тэгш бололцоо, шударга ёсыг хэрэгжүүлье.

Монголын Социал Демократ Нам





2012 оны 5 сарын 4 өдөр
Date:

Дугаар ...
Our ref ...

Улаанбаатар
Ulaanbaatar

Монголын Социал Демократ Намын Улс төрийн зөвлөлийн хурлын

Тогтоол №02


Улаанбаатар хот

2012 оны 05 сарын 04

Монгол Улсын Үндэсний Аудитын Газраас МСДН – ын УИХ – ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийж гаргасан дүгнэлтийг үндэслэн тогтоох нь:

1.МСДН – ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн 3-р бүлгийн Уул уурхай, ашигт малтмал хэсэгт орсон Иргэн бүрт стратегийн орд газруудын хувьцааг олгох амлалт бүхий хэсгийг хасч өөрчлөн найруулсугай.

МСДН – ын даргын үүрэг гүйцэтгэгч



/Д.Энхзаяа/



2012 оны 5 сарын 4 өдөр
Date:

Дугаар ... 104
Our ref ...


Улаанбаатар
Ulaanbaatar

Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороонд

Монголын Социал Демократ Нам 2012 оны УИХ – ын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрөө хүүлийн хугацаанд Монгол Улсын Үндэсний Аудитын Газарт хүргүүлж дүн шинжилгээ хийлгэсэн билээ. Энэхүү дүн шинжилгээнд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хүүлийн 34.3 дахь хэсэгт заасан заалтад нийцээгүй амлалт орсон байна гэж дүгнэсэн тул тус намын төлөөллийн төв байгууллага болох УТЗөвлөл 2012 оны 05 сарын 04 – ний өдөр дахин мөрийн хөтөлбөрөө хянан хэлэлцэж тус хөтөлбөрийн Эзэнтэй нутаг бүлэгт орсон “... Иргэн бүрт стратегийн орд газруудын хувьцааг олгох ажлыг тасралтгүй хэрэгжүүлэх...” тухай заалт нь нэгэнт төрийн бодлого болон хэрэгжиж байгаа тул уг заалтыг мөрийн хөтөлбөрөөс хасаж хуульд нийцүүлэх шийдвэр гаргалаа.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хүүлийн 25.4 –т заасны дагуу УИХ – ын сонгуульд оролцох МСДН – ын өөрчлөн найруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хүргүүлж байна.

МСДН – ын даргын үүрэг гүйцэтгэгч



/Д.Энхзаяа/

Жич: Хувийг Монгол Улсын Үндэсний Аудитын Газарт